



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/087

Номгон

“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнийг
хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагын дагуу “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн”, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“а”, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 31 дүгээр зүйлийн 31.1, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/7 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”- ийн 5.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн ХЭГ/2358 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөнийг цаашид аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулж иргэн аж ахуйн нэгжийг эх байгалиа хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд идэвх санаачлагатай оролцуулах арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлан мэдээг хагас, бүтэн жилээр Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт чанартай, үнэн зөв тайлагнаж ажиллахыг Сум дундын ойн анги (П.Уртнасан)-д үүрэг болгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Жишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601210601